INTER AUDIT

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"Тус Финтек ББСБ" ХХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

УЛААНБААТАР ХОТ, 2024 ОН

"ИНТЕР АУДИТ" ХХК



АГУУЛГА

I. ХАРААТБУС АУДИТОРЫН ТАЙЛАН

II. ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

III. 2023 ОНЫ АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

IV. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2024.03.11

“ТУС ФИНТЕК ББСБ” ХХК-ИЙН МЭДЭЭЛЭЛ

КОМПАНИЙН НЭР:	“Тус Финтек ББСБ” ХХК
РЕГИСТРИЙН ДУГААР:	6715249
КОМПАНИЙН УДИРДЛАГА:	М.Гантулга
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД:	Б.Хүрэлхүү /40%/ С.Болормаа /40%/ Б.Саруул /20%/
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:	Зээлийн үйл ажиллагаа
КОМПАНИЙН ХАЯГ:	Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, 6-р хороолол, бага тойруу, 50 байр, 16 тоот
ХОЛБОО БАРИХ:	99113893, 99995958

АУДИТЫН КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

INTER AUDIT

АУДИТОР, МЭРГЭШСЭН НЯГТЛАН БОДОГЧИД,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: Ч.МӨНХБАЯР

Аудитын компанийн хаяг:

Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, 6-р хороолол, Самбуугийн гудамж, Эм Эн тауэр, 802 тоот

Холбогдох:

Утас: 99004839
Веб хуудас: www.interaudit.mn
Фэйсбүүк хуудас: Интер Аудит ХХК / Inter Audit LLC
Мэйл хаяг: info@interaudit.mn

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2024.03.11

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

1

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"ТУС ФИНТЕК ББСБ" ХХК-ИЙН УДИРДЛАГАД

ДҮГНЭЛТ

Бид 2023 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн "Тус Финтек ББСБ" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж буйгаар "Тус Финтек ББСБ" ХХК-ийн 2023 оны 12-р сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал ба уг өдрөөр болсон жилийн орлогын дэлгэрэнгүй орлогын тайлан ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын, Нягтлан бодох бүртгэлийн стандартуудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

ДҮГНЭЛТИЙН ҮНДЭСЛЭЛ

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн талаарх аудиторын үүрэг хариуцлага хэсэгт харуулав. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон Монгол Улсын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих шаардлагуудын дагуу тус байгууллагаас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж итгэж байна.

УДИРДЛАГА БОЛОН ЗАСАГЛАХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДҮҮДИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХҮЛЭЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэгтэй бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Удирдлага нь санхүүгийн тайланг гаргахдаа байгууллагын үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангаа гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу зогсолтгүй үйл ажиллагаа явуулах байгууллагын чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх бүхий этгээдүүд нь байгууллагын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2024.03.11

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТАД ХҮЛЭЭХ АУДИТОРЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөртүвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж, аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

1. Залилан эсвэл алдааны улмаас тусдаа санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай ба зохистой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүйбайх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.

2. Байгууллагын дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоодхяналтын талаар ойлголт олж авдаг.

3. Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.

4. Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн байгууллагын тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

5. Тодруулгыг багтаагаад тусдаа санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж тусдаа санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Хүндэтгэсэн,

"ИНТЕР АУДИТ" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ЧИМЭНХБАЯР

Тайлангийн огноо: 2024/03/11

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2024.03.11

ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2

АУДИТ ХИЙСЭН ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	2022.12.31	2023.12.31
А. ҮЛДЭГДЛИЙН ТЭНЦЭЛ		
1. Мөнгөн хөрөнгө	441,279,311.44	1,193,806,931.10
2. Нийт зээл	10,521,019,918.62	22,230,164,779.31
3. Зээлийн эрсдэлийн сан	(221,354,242.81)	(494,153,273.07)
4. Бусад авлага	20,062,587.02	22,461,095.87
5. Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	598,955,221.35	1,342,391,570.89
6. Урьдчилж төлсөн тооцоо	1,565,850.00	126,960,777.31
7. Бараа материал	1,900,070.00	9,318,864.00
Эргэлтийн хөрөнгийн дүн	**11,363,428,715.62**	**24,430,950,745.41**
8. Үндсэн хөрөнгө	132,451,253.15	246,103,636.37
9. Биет бус хөрөнгө	78,729,351.93	2,100,512,152.98
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	**211,180,605.08**	**2,346,615,789.35**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	11,574,609,320.70	26,777,566,534.76
1. Богино хугацаат өглөг	1,826,343,788.54	8,842,145,922.51
2. Урт хугацаат өглөг	4,321,508,000.00	4,295,508,000.00
Өр төлбөрийн дүн	**6,147,851,788.54**	**13,137,653,922.51**
3. Өмч	2,500,000,000.00	2,500,000,000.00
4. Өмчийн бусад хэсэг	-	-
5. Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	2,211,751,431.00
7. Хуримтлагдсан ашиг	2,926,757,532.24	8,928,161,181.25
Эзэмшигчийн өмчийн дүн	**5,426,757,532.24**	**13,639,912,612.25**
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	11,574,609,320.78	26,777,566,534.76
Б. ОРЛОГЫН ТАЙЛАН		
1. Хүүгийн орлого	5,618,702,501.70	11,518,182,657.80
2. Хүүгийн зардал	803,383,166.55	1,771,938,838.87
3. Цэвэр хүүгийн орлого /1-2/	4,815,319,335.15	9,746,243,818.93
4. Хүүгийн бус орлого	104,082,851.60	470,458,922.03
5. Хүүгийн бус зардал	1,364,641,416.10	2,997,215,638.26
6. Цэвэр хүүгийн бус орлого/зардлын дүн /4-5/	(1,260,558,564.50)	2,526,756,716.23
7. Болзошгүй эрсдэлийн сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг/алдагдал /3-6/	3,554,760,770.65	7,219,487,102.70
8 Болзошгүй эрсдэлийн зардал	221,354,242.81	273,789,292.20
9. Үндсэн үйл ажиллагааны ашиг/алдагдал /7-8/	**3,333,406,527.84**	**6,945,697,810.50**
10. Үндсэн бус үйл ажиллагааны орлого	-	6,949,142.82
11. Үндсэн бус үйл ажиллагааны зардал	65,350,903.01	164,920,621.11
12. Ердийн үйл ажиллагааны ашиг/алдагдал /9+10-11/	**3,268,055,624.83**	**6,787,726,332.21**
13. Ердийн бус орлого	-	-
14. Ердийн бус зардал	-	-
15. Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал /12+13-14/	**3,268,055,624.83**	**6,787,726,332.21**
16. Орлогын татварын зардал	328,653,502.02	797,216,283.12
17. ЦЭВЭР АШИГ/АЛДАГДАЛ /15-16/	2,939,402,122.81	5,990,510,049.09
В. ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН		
1. Эхний үлдэгдэл	2,459,672,076.10	5,426,757,532.24
2. Нэмэгдсэн	2,967,085,456.14	8,213,155,080.01
3. Хорогдсон		
4. Эцсийн үлдэгдэл	5,426,757,532.24	13,639,912,612.25
Г. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН		
1. Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	3,432,531,588.67	6,270,324,315.97
2. Үндсэн бус үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(3,386,246,580.21)	(5,517,756,696.31)
3. Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	46,285,008.46	752,567,619.66

ИНТЕР АУДИТ
№ 01 огноо 2024.03.11

2023 ОНЫ АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

3

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	ТОД	2022.12.31	2023.12.31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ			
Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	4	441,279,311.44	1,193,806,931.10
Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/		-	-
Нийт зээл	5	10,521,019,918.62	22,230,164,779.31
Зээлийн эрсдэлийн сан	5	(221,354,242.81)	(494,153,273.07)
Санхүүгийн түрээсийн тооцооны авлага /цэврээр/		-	-
Факторингийн тооцооны авлага /цэврээр/		-	-
Санхүүгийн дериватывын авлага		-	-
Бусад авлага	7	20,062,587.02	22,461,095.87
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	6	598,955,221.35	1,342,391,570.89
Урьдчилж төлсөн тооцоо	8	1,565,850.00	126,960,777.31
Бараа материал	8	1,900,070.00	9,318,864.00
Эргэлтийн хөрөнгийн дүн		**11,363,428,715.62**	**24,430,950,745.41**
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ			
Үндсэн хөрөнгө	9	132,451,253.15	246,103,636.37
Биет бус хөрөнгө	10	78,729,351.93	2,100,512,152.98
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		**211,180,605.08**	**2,346,615,789.35**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		11,574,609,320.70	26,777,566,534.76
ӨР ТӨЛБӨР			
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР			
Банк, санхүүгийн байгууллагаас авсан богино хугацаат зээл	11	1,087,688,500.00	2,353,623,661.11
Банк, санхүүгийн байгууллагаас авсан богино хугацаат зээлийн хугацаа хэтрэлт		-	-
Өрийн бичгээрх өглөг		-	-
Санхүүгийн дериватывын өглөг		-	-
Төслийн зээлийн богино хугацаат санхүүжилт		-	-
Итгэлцлийн үйлчилгээний өглөг		-	-
Факторингийн үйлчилгээний өглөг		-	-
Мөнгөн гуйвуулгын өглөг		-	-
Зээлийн батлан даалтад байршуулсан эх үүсвэр		-	-
Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	11	283,761,987.39	545,068,596.11
Цалингийн өглөг	12	29,094,264.06	65,240,746.39
ЭМД, НДШ-ийн өглөг	13	20,632,146.88	11,269,889.02
Татварын өглөг	13	357,310,764.89	848,491,800.93
Бусад богино хугацаат өр төлбөр	12	47,856,125.32	5,018,451,228.95
Богино хугацаат өр төлбөрийн дүн		**1,826,343,788.54**	**8,842,145,922.51**
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР			
Урт хугацаат зээл	12	4,321,508,000.00	4,295,508,000.00
Урт хугацаат өр төлбөр	-	-	-
Бусад урт хугацаат өр төлбөр	-	-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн		**4,321,508,000.00**	**4,295,508,000.00**
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН		6,147,851,788.54	13,137,653,922.51

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2024.03.11

ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ			
Өмч: -төрийн		-	-
- хувийн	14	2,500,000,000.00	2,500,000,000.00
-хувьцаат		-	-
Халаасны хувьцаа		-	-
Нэмж төлөгдсөн капитал		-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	15	-	2,211,751,431.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		-	-
Эздийн өмчийн бусад хэсэг		-	-
Хуримтлагдсан ашиг	16	2,926,757,532.24	8,928,161,181.25
Эзэмшигчдийн өмчийн дүн	**-**	**5,426,757,532.24**	**13,639,912,612.33**
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН	-	11,574,609,320.78	26,777,566,534.84

Хавсралт, тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 тоот 2024.03.11

АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	ТОД	2022.12.31	2023.12.31
Хүүгийн орлого		**5,618,702,501.70**	**11,518,182,657.80**
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	17	5,502,333,759.66	11,238,387,689.62
Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	17	116,368,742.04	265,640,465.61
Үнэт цаасны хүүгийн орлого		-	-
Хугацаандаа байгаа санхүүгийн түрээсийн хүүгийн орлого		-	-
Хугацаа хэтэрсэн санхүүгийн түрээсийн хүүгийн орлого		-	-
Хугацаандаа байгаа Факторингийн үйлчилгээний хүүгийн орлого		-	-
Хугацаа хэтэрсэн Факторингийн үйлчилгээний хүүгийн орлого		-	-
Харилцах дансны хүүгийн орлого	17	-	184,201.54
Банкин дахь хадгаламжийн хүүгийн орлого	17	-	13,970,301.03
Хүүгийн орлогын буцаалт		-	-
Хүүгийн зардал	-	**803,383,166.55**	**1,771,938,838.87**
Банкны байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал	17	803,383,166.55	-
Бусад санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал	17	-	1,771,938,838.87
Төслийн зээлийн санхүүжилтын хүүгийн зардал		-	-
Өрийн бичгийн хүүгийн зардал		-	-
Хүүгийн зардлын буцаалт		-	-
ЦЭВЭР ХҮҮГИЙН ОРЛОГО	-	**4,815,319,335.15**	**9,746,243,818.93**
Хүүгийн бус орлого	-	**104,082,851.60**	**470,458,922.03**
Арилжааны цэвэр орлого		-	-
Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого		-	-
Санхүүгийн үйлчилгээний шимтгэл	18	104,082,851.60	470,458,922.03
Хүүгийн бус зардал	-	**1,364,641,416.10**	**2,997,215,638.26**
Арилжаа болон ханшийн тэгшитгэлийн зардал		-	-
Боловсон хүчний холбогдолтой зардал	18	775,650,089.10	1,690,833,867.22
Бусад зардал	18	588,991,327.00	1,306,381,771.04
ЦЭВЭР ХҮҮГИЙН БУС ОРЛОГО/ЗАРДЛЫН ДҮН		**(1,260,558,564.50)**	**(2,526,756,716.23)**
БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН САН БАЙГУУЛАХААС ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ/АЛДАГДАЛ		3,554,760,770.65	7,219,487,102.70
Болзошгүй эрсдэлийн зардал		**221,354,242.81**	**273,789,292.20**
Үнэт цаасны эрсдэлийн зардал		-	-
Зээлийн эрсдэлийн зардал	19	221,354,242.81	273,789,292.20
Санхүүгийн түрээсийн үйлчилгээний эрсдэлийн зардал		-	-
Факторингийн үйлчилгээний эрсдэлийн зардал		-	-
Найдваргүй авлагын нөөцийн зардал		-	-
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн эрсдэлийн зардал		-	-
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ/АЛДАГДАЛ		**3,333,406,527.84**	**6,945,697,810.50**

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2024. 03. 11

Үндсэн бус үйл ажиллагааны орлого		-	**6,949,142.82**
Алданги		-	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		-	-
Ногдол ашгийн орлого		-	-
Хандив		-	-
Тэнцлийн гадуурх тооцооноос хийгдсэн төлөлт		-	-
Бусад	20	-	6,949,142.82
Үндсэн бус үйл ажиллагааны зардал		**65,350,903.01**	**164,920,621.11**
Зочин төлөөлөгчийн зардал	20	33,198,202.00	-
Торгуулийн зардал	20	-	190,000.00
Хөрөнгө данснаас хассаны гарз	20	485,936.56	-
Хөрөнгө данснаас хассаны гарз	20	-	131,700,292.00
Бусад	20	31,666,764.45	33,030,329.11
ЕРДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ/АЛДАГДАЛ		**3,268,055,624.83**	**6,787,726,332.21**
Ердийн бус орлого		-	-
Ердийн бус зардал		-	-
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ/АЛДАГДАЛ		**3,268,055,624.83**	**6,787,726,332.21**
Орлогын татварын зардал	21	328,653,502.02	797,216,283.12
Цэвэр ашиг/алдагдал		**2,939,402,122.81**	**5,990,510,049.09**

Хавсралт, тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2024.03.11

АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМЧ	НЭМЖ ТӨЛӨГДСӨН КАПИТАЛ	ХӨРӨНГИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ	ЭЗНИЙ ӨМЧИЙН БУСАД ХЭСЭГ	ХУРИМТЛАГДСАН АШИГ (АЛДАГДАЛ)	НИЙТ ДҮН
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**2,500,000,000.00**	-	-	-	**(40,327,923.90)**	**2,459,672,076.10**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	27,683,333.33	27,683,333.33
ЗАЛРУУЛСАН ҮЛДЭГДЭЛ	**2,500,000,000.00**	-	-	-	**(12,644,590.57)**	**2,487,355,409.43**
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	2,939,402,122.81	2,939,402,122.81
Бусад дэлгэрэнгүй орлого						
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**2,500,000,000.00**	-	-	-	**2,926,757,532.24**	**5,426,757,532.24**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	10,893,599.92	10,893,599.92
ЗАЛРУУЛСАН ҮЛДЭГДЭЛ	**2,500,000,000.00**	-	-	-	**2,937,651,132.16**	**5,437,651,132.16**
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		-	-	-	5,990,510,049.09	5,990,510,049.09
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-		-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	2,211,751,431.00	-	-	2,211,751,431.00
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ҮЛДЭГДЭЛ	**2,500,000,000.00**	-	**2,211,751,431.00**	-	**8,928,161,181.25**	**13,639,912,612.25**

Хавсралт, тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2024.03.11

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	2022.12.31	2023.12.31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	**5,211,064,963.73**	**10,896,102,363.35**
Зээлийн хүүгийн орлого	5,106,707,112.79	10,428,525,956.78
Үнэт цаасны хүүгийн орлого	-	18,705.54
Факторингийн үйлчилгээний хүүгийн орлого	-	-
Харилцах дансны хүүгийн орлого	-	-
Банкин дахь хадгаламжийн хүүгийн орлого	-	13,970,301.03
Санхүүгийн түрээсийн орлого	-	-
Гадаад валютын арилжааны орлого	-	-
Үнэт цаасны арилжааны орлого	-	-
Гадаад валютын ханшийн зөрүү	-	-
Үнэт цаасны үнэлгээний зөрүү	-	-
Итгэлцлийн үйлчилгээний орлого	-	-
Мөнгөн гуйвуулгын орлого	-	-
Картын үйлчилгээний орлого	-	-
Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	-	-
Санхүүгийн түрээсийн орлого	-	-
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	100,991,550.94	453,434,400.00
Хүүгийн орлогын буцаалт	3,366,300.00	153,000.00
Бусад үйлчилгээний орлого	-	-
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГА	**1,778,533,375.06**	**4,625,778,047.38**
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал	508,275,939.34	1,483,380,431.52
Төслийн зээлийн санхүүжилтийн хүүгийн зардал	-	-
Өрийн бичгийн хүүд төлсөн мөнгө	-	-
Хүүгийн зардлын буцаалт	-	-
Үндсэн ба нэмэгдэл цалин	531,298,899.42	1,152,535,520.67
Ажилтнуудад олгосон нөхөн олговор, тэтгэмж	-	-
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал	136,937,666.61	138,566,217.73
Албан томилолт, сургалтын зардал	1,375,000.00	37,409,500.00
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	89,590,076.98	122,916,436.58
Шатахуун, холбоо, интернэт, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	4,354,250.00	494,248,455.21
Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал	23,979,702.53	31,217,397.00
Татвар, даатгалын төлсөн мөнгө	37,894,045.83	665,103,177.33
Зар сурталчилгаанд төлсөн мөнгө	-	110,086,458.88
Үнэт цаас болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбоотой гарсан мөнгө	-	-
Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан мөнгө	365,884,194.35	5,649,770.00
Факторинг болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан мөнгө	-	-
Итгэлцлийн үйлчилгээ болон түүнтэй холбогдон гарсан мөнгө	-	-
Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаатай холбогдон гарах мөнгө	-	-
Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө	75,943,600.00	11,880,000.00
Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө	3,000,000.00	3,240,000.00
Ногдол ашгаар олгосон мөнгө	-	-
Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн бусад мөнгө	-	325,749,835.00
Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	-	43,794,847.46
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	**3,432,531,588.67**	**6,270,324,315.97**

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 оноо 2024.03.11

ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	**62,072,230,313.49**	**158,736,363,529.20**
Үндсэн ба хөрөнгө борлуулсны орлого	-	-
Ногдол ашгийн орлого	-	-
Хандив	-	-
Бусад орлого	62,072,230,313.49	158,736,363,529.20
ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГА	**65,458,476,893.70**	**164,254,120,225.51**
Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардал	33,198,202.00	130,121,750.00
Торгуулийн зардал	-	140,000.00
Бусад зардал	65,425,278,691.70	164,123,858,475.51
ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	**(3,386,246,580.21)**	**(5,517,756,696.31)**
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	**46,285,008.46**	**752,567,619.66**
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	394,994,302.98	441,279,311.44
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	441,279,311.44	1,193,806,931.10

Хавсралт, тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2024.03.11

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

4

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ БА ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

"Тус Финтек ББСБ" ХХК нь 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газар бүртгэгдэж, 9015005132 хувийн хэргийн дугаар, 6715249 регистрийн дугаартай гэрчилгээ авсан. 2021 оны 06 дугаар сарын 10-нд М.Гантулга-г гүйцэтгэх захирлаар томилсон.

Санхүүгийн зохицуулах хорооноос 2021 оны 10 дугаар сарын 13-нд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авч, Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 21/01 тоот тогтоолоор дүрмийн санг 2,500,000,000.00 төгрөгөөр тогтоосон бөгөөд нэг бүр нь 2,500,000.00 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1000 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байна.

Компани нь 3 хувьцаа эзэмшигчидтэй бөгөөд Б.Хүрэлхүү нь компанийн 40 хувь, С.Болормаа нь компанийн 40 хувь, Б.Саруул нь компанийн 20 хувийг тус тус эзэмшдэг.

2. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН СУУРЬ ЗАРЧИМ

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДЭС:

Компанийн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-д нийцүүлэн бэлтгэсэн. Санхүүгийн тайлангууд нь санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тайлбар тодруулгаас бүрдэж байна.

ҮНЭЛГЭЭ:

Санхүүгийн тайланд хөрөнгө, өр төлбөр, өмчийг түүхэн өртгийн зарчмаар хэмжиж бүртгэсэн.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН ВАЛЮТ:

Компанийн ажил гүйлгээний хэмжих нэгж нь Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөг (MNT) юм. Санхүүгийн тайлангийн тодруулгад тоон үзүүлэлтүүдийг төгрөгөөр бэлтгэсэн.

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН СУУРЬ:

Санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт зарчимд үндэслэн бэлтгэдэг.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ТӨСӨӨЛӨЛ:

Мөрдөж байгаа хууль эрх зүйн болон бизнесийн орчинд компанийн цаашдын үйл ажиллагаанд нөлөөлөхүйц өөрчлөлт орох хандлага ба төсөөлөлгүй байна. Компани ирээдүйд үндсэн үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэн явуулна гэсэн итгэл үнэмшилд тулгуурлан санхүүгийн тайлангаа бэлтгэсэн.

СТОУС-ЫН ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛТ:

2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон, СТОУС-ын нэмэлт өөрчлөлтүүдээс бусад нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг өмнөх санхүүгийн жилүүдэд тууштай хэрэгжүүлсэн. Дараах өөрчлөлтүүд СТОУС-д орсон ба тайлант үе болон дараагийн тайлант үеүдэд мөрдөгдөхөөр байна:

СТОУС 3-т орсон нэмэлт өөрчлөлт: Бизнесийн тодорхойлолт: СТОУС 3 Бизнесийн нэгдэлд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр бизнес нь дор хаяж үйл ажиллагаа болон хөрөнгийн цогцдоо эцсийн бүтээгдэхүүнийг гаргах чадамжид их хэмжээгээр нөлөөлж чадахуйц орц болон бодит үйл явцын нэгдлийг багтаасан байх ёстой. Цаашилбал, бизнес нь эцсийн бүтээгдэхүүнийг бий болгоход шаардагдах бүх орц болон процесстэйгээр оршин тогтнох шаардлагагүй болохыг тодруулсан болно. Уг нэмэлт өөрчлөлт Компанийн санхүүгийн тайланд нөлөөгүй боловч Компани ирээдүйд аливаа бизнесийн нэгдэлд орох тохиолдолд нөлөөлж болзошгүй юм.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2024.03.11

СТОУС 3-т орсон нэмэлт өөрчлөлт: Бизнесийн тодорхойлолт: СТОУС 3 Бизнесийн нэгдэлд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр бизнес нь дор хаяж үйл ажиллагаа болон хөрөнгийн цогцдоо эцсийн бүтээгдэхүүнийг гаргах чадамжид их хэмжээгээр нөлөөлж чадахуйц орц болон бодит үйл явцын нэгдлийг багтаасан байх ёстой. Цаашилбал, бизнес нь эцсийн бүтээгдэхүүнийг бий болгоход шаардагдах бүх орц болон процесстэйгээр оршин тогтнох шаардлагагүй болохыг тодруулсан болно. Уг нэмэлт өөрчлөлт Компанийн санхүүгийн тайланд нөлөөгүй боловч Компани ирээдүйд аливаа бизнесийн нэгдэлд орох тохиолдолд нөлөөлж болзошгүй юм.

НББОУС 1, НББОУС 8-д орсон нэмэлт өөрчлөлт: Материаллаг байдлын тодорхойлолт: Нэмэлт өөрчлөлт нь "Материаллаг"-г шинэ тодорхойлолтыг: "Тайлагнагч байгууллагын санхүүгийн тайланд аливаа мэдээллийг орхигдуулах, эсвэл буруу ташаа, тодорхой бус байдлаар илэрхийлэх нь байгууллагын санхүүгийн тайлангийн үндсэн хэрэглэгчдийн уг тайланг үндэслэн гаргах шийдвэрт үндэслэлтэйгээр нөлөөлж болзошгүй тохиолдолд тухайн мэдээллийг материаллаг гэж үзнэ." гэжээ. Нэмэлт өөрчлөлтүүд нь "материаллаг"-г санхүүгийн тайлангийн агуулгаар, тухайн мэдээллийн шинж чанар ба/эсвэл хэмжээгээс хамаарна гэдгийг тодорхойлсон. Мэдээллийг буруу ташаа илэрхийлэх нь үндсэн хэрэглэгчдийн гаргах шийдвэрт үндэслэлтэйгээр нөлөөлөхүйц бол үүнийг материаллаг гэж үзнэ. Эдгээр нэмэлт, өөрчлөлт нь санхүүгийн тайланд нөлөөлөөгүй бөгөөд цаашид Компанид нөлөөлөхгүй гэж үзэж байна.

2018 оны 3 дугаар сарын 29-ний өдөр гаргасан Санхүүгийн тайлагналын суурь үзэл баримтлал: СТОУС 16-д орсон нэмэлт өөрчлөлт: Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлт 2020 оны 5 дугаар сарын 28-нд НББОУСЗ нь Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлтийн тухай СТОУС 16 Түрээс–д нэмэлт, өөрчлөлт оруулсан. Нэмэлт өөрчлөлтүүд нь түрээслэгчдэд Ковид-19 цар тахлын шууд үр дагаврааc үүдэлтэй түрээсийн хөнгөлөлтийг бүртгэх түрээсийн өөрчлөлтийн бүртгэлийн талаарх СТОУС 16–ийн зааврыг хэрэгжүүлэхэд хөнгөлөлт үзүүлдэг. Энэхүү хөнгөлөлтийн зорилго нь түрээслэгч нь түрээслүүлэгчээс Ковид-19-тэй холбоотой авсан түрээсийн хөнгөлөлтийг түрээсийн өөрчлөлт мөн эсэхийг үнэлэхгүй байж болох сонголтыг оруулж өгсөн. Энэ сонголтыг хийсэн түрээслэгч нь Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлтийг СТОУС 16-д заасан түрээсийн өөрчлөлт гэж үзээгүй үед тооцсонтой адил аргаар тооцно. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2020 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс хойших жилийн тайлангийн хугацаанд хамаарна. Эрт хэрэгжүүлж эхлэхийг зөвшөөрнө.

Компанийн санхүүгийн тайлангуудыг бэлтгэж гаргах өдрийн байдлаар батлагдаж гарсан боловч хэрэгжиж эхлээгүй стандартуудыг доор үзүүлэв. Компани энэхүү стандартуудыг (хэрэв Компанид хамааралтай бол) хүчин төгөлдөр үйлчилж эхлэх өдрөөс мөрдөх хандлагатай байна.

НББОУС 1-т орсон нэмэлт өөрчлөлт - Эргэлтийн болон эргэлтийн бус өр төлбөрийн ангилал 2

СТОУС 3-т орсон нэмэлт өөрчлөлт - Үзэл баримтлалын хүрээний тайлбар 1

НББОУС 16-д орсон нэмэлт өөрчлөлт - Үндсэн хөрөнгө: Зориулалтаар ашиглаж эхлэхээс өмнөх орлого 1

НББОУС 37-д орсон нэмэлт өөрчлөлт - Онцгой гэрээ – Гэрээний үүрэг биелүүлэх зардал 1

СТОУС 1 СТОУС-ыг анхлан хэрэгжүүлэх - Охин компани нь анхлан хэрэгжүүлэгч 1

НББОУС 41 Газар тариалан - Бодит үнэ цэнийн хэмжилтэд татвар ногдуулах тухай.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2024.05.11

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД

Компани нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ СТОУС-ыг мөрдлөг болгосон. Тайлант онд дараах нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын дагуу санхүүгийн тайлангаа толилуулсан байна.

МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө, төлбөр гүйцэтгэх зориулалтаар банкин дахь харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгүүдээс бүрдэнэ. Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлсийг нэрлэсэн үнээр нь бүртгэдэг. Гадаад валютаарх мөнгөн хөрөнгийг Монгол банкнаас зарласан тухайн өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлнэ.

ГАДААД ВАЛЮТЫН БҮРТГЭЛ

Санхүүгийн тайланг Монгол төгрөгөөр илэрхийлсэн бөгөөд компани үйл ажиллагаагаа явуулдаг албан ёсны мөнгөн тэмдэгт нь Монголулсын мөнгөн тэмдэгт - Монгол төгрөг (MNT) юм. Гадаад улс орны валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөр, гүйлгээг тайлан гаргасан өдрийн Монгол банкнаас зарласан албан ханшаар төгрөгт хөрвүүлж санхүүгийн тайланд тусгана.

Хөрвүүлэлтээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүүг орлого үр дүнгийн тайланд ашиг (алдагдал)-аар хүлээн зөвшөөрнө. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг нэрлэсэн үнээр нь бүртгэдэг бөгөөд нэрлэсэн үнийг тухайн өдрийн ханшаар хөрвүүлэн бүртгэлд тусгана.

САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

Санхүүгийн хөрөнгөнд мөнгө, авлага, зээл, бусад байгууллагын өмчийн хэрэгсэл, санхүүгийн хөрөнгийг авах гэрээний эрх, үүсмэл санхүүгийн хэрэглүүр, тэдгээртэй ижил төстэй гэрээ, хэлцэл багтана. Тухайн хөрөнгөтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөж нь аж ахуй нэгжид орох нилээд их их магадлалтай, хөрөнгийн өртгийг найдвартайгаар хэмжиж чадах үед хөрөнгийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрийг Монгол банкнаас зарласан албан ханшаар үнэлж, ханшийн зөрүүг тайлант хугацааны ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийн хүүг өдөр тутам хуримтлуулж бүртгэнэ. Санхүүгийн хөрөнгө, түүний бүрэлдэхүүн хэсэгтэй холбоотой хүү, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт, олз, гарзыг тухайн тайлант хугацаанд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

ЗЭЭЛ

Зээлийг гэрээний нэг тал болсон үед санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, толилуулна. Зээлийн хугацаа дууссан, зээлдэгч гэрээнд заасан төлбөрөө барагдуулж, хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн, эсхүл гэрээгээр үүссэн эрхээ бусдад бүрэн шилжүүлсэн тохиолдолд зээлийг данснаас хасаж бүртгэнэ. Зээлийг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр нь хэмжих ба хэрэв зээл олгохтой шууд холбоотой ажил гүйлгээний зардал гарсан бол уг зардлыг бодит үнэ цэнэ дүн дээр нэмэх эсвэл хасах байдлаар хэмжинэ. Санхүүгийн тайланд зээлийг хорогдуулсан өртгөөр хэмжиж, тайлагнана. Зээлийн хорогдуулсан өртөг нь зээлийг анх хүлээн зөвшөөрч хэмжсэн дүнгээс буцаан төлсөн зээлийн үндсэн төлбөрийн төлөлтийг хасаж, хойшлогдсон орлого, зардлыг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулан хуримтлуулсан дүнг хасах, эсхүл нэмж, зээлийн эрсдэлийн санг хассан дүн байна.

Зээлдэгч тал үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болсон шимтгэл, хураамжийг хойшлуулан бүртгэж, холбогдох эх үүсвэрийн дүнг бууруулна. Үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болсон шимтгэл, хураамжийг хоёр төрөлд ангилж болно:

а) зээл олгохтой холбоотой шимтгэл, хураамж (зээл олголтын хураамж)

б) хэлцэлд заасан үүрэгтэй холбоотой шимтгэл, хураамж (хүлээсэн үүргийн хураамж).

Компани нь зээл олголтоо 4 ангилж зээлдүүлэгчдэд олгодог бөгөөд ангиллаас хамааран зээлийн хүү нь өөр өөр байна;

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2024.03.11

ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН САН (ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ)

Компани нь Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ын дагуу сар бүр зээлийн эрсдэлийн санг байгуулна. Түүнчлэн тайлант жилийн эцэст зээлийн үнэ цэнийн бууралтыг СТОУС-9-д нийцүүлэн тооцож болно.

СТОУС 9-д заасан үнэ цэнийн бууралтын загвар нь хүлээгдэж буй алдагдлын загвар бөгөөд алдагдал үүсэх үйл явдал тохиолдохоос өмнө үнэ цэнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрдөг. Иймд компани нь зээлийн үнэ цэнийн бууралтыг хүлээгдэж буй зээлийн алдагдлын дүнгээр үнэлж, бүртгэнэ.
Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмын дагуу зээлийг хугацаа болон чанарын үзүүлэлтээр нь хэвийн, хугацаа хэтэрсэн, хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл гэж ангилна. Зээлийн эрсдэлийн сангийн зардал (үнэ цэнийн бууралт)-ыг тооцохдоо Санхүүгийн зохицуулах хорооноос батлагдсан "Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ыг баримтална. Холбогдох активын ангиллын журмаар тооцоолсон зээлийн эрсдэлийн сангийн дүн нь СТОУС-ын дагуу байгуулах эрсдэлийн сангаас бага гарвал СТОУСын дагуу тооцоолсон дүнгээр эрсдэлийн сангийн зардлыг бүртгэх ба түүнээс илүү гарсан дүнгээр эрсдэлийн сангийн нөөцөд бүртгэнэ.

БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалыг олж бэлтгэсэн өртгөөр үнэлэн, ижил төрлийн хөрөнгүүдийг эхэлж авснаа эхэлж зарлагадах аргаар бүртгэнэ. Аж ахуйн ба хангамжийн материал, бараа, бүтээгдэхүүнийг төрөл зүйлээр ангилан санхүүгийн тайланд бүлэглэн үзүүлнэ.

УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ, ТООЦОО

Гадаад болон дотоодын зах зээлээс түүхий эд материал худалдан авахаар төлсөн төлбөр, бусад бэлтгэн нийлүүлэгч, гэрээ гүйцэтгэгчид төлсөн урьдчилгааг нэрлэсэн үнээр нь хэмжиж, урьдчилж төлсөн зардал, урьдчилж төлсөн тооцооны хэсэгтнэрийн данс нээж бүртгэдэг.

ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн ба санхүүгийн тайлагналын олон улсын стандарт,хүлээн зөвшөөрөх нөхцөлийн дагуу, анхны өртгөөр хэмжиж үнэлэн зохих ангиллын дансанд бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн өртөг нь худалдан авалтын өртөг, хөрөнгийг ашиглалтын хэвийн нөхцөлд оруулахад шууд хамаарах зардлаас бүрдэнэ. Анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан цэвэр дүнгээр санхүүгийн тайландтусгана.

Үндсэн хөрөнгө ашиглагдах хугацаандаа өртгөө нөхөхөөр тооцож элэгдлийг шулуун шугамын аргаар санхүүгийн тайлагналын зорилгоор байгуулж орлогын тайланд тусгадаг.

БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Хөрөнгө нь дараах шалгуурын аль нэгийг хангаж байвал тодорхойлж болох хөрөнгө гэж үзнэ:

а) Салган хуваж болох ба компани тийм зорилготой эсэхээс үл хамааран холбогдох гэрээ, тодорхойлж болох хөрөнгө, өр төлбөрөөс бие даасан байдлаар эсхүл хамтад нь борлуулах, шилжүүлэх, лицензээр эзэмшүүлэх, түрээслэх, солилцох боломжтой байх; эсхүл

б) Гэрээний болон бусад хуулийн эрхийг шилжүүлж болох буюу тухайн компаниас эсхүл өөр бусад эрх, үүргээс салган тусгаарлаж болох эсэхээс үл хамааран тухайн гэрээний буюу бусад хуулийн эрхээс үүссэн байх.

Биет бус хөрөнгийг тухайн хөрөнгөд хамаарах хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж нь уг аж ахуйн нэгжид орох магадлалтай, хөрөнгийн өртгийг найдвартай хэмжиж чадах шалгуурыг хангаж байвал хүлээн зөвшөөрнө. Худалдаж авсан биет бус хөрөнгийг хөрөнгийг өртгөөр нь үнэлж, бүртгэнэ. Компани нь биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа тодорхой бол ашиглалтын шулуун шугамын аргаар хорогдуулдаг. Хэрвээ хөрөнгийн ашиглалтын хугацаа тодорхойгүй бол хорогдуулахгүй, үнэ цэнийн бууралтыг үнэлж бүртгэнэ.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2024.03.11

УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Урт хугацаат хөрөнгө оруулалтыг мөнгөөр хийсэн бол нэрлэсэн үнээр, мөнгөнөөс бусад хөрөнгөөр хийсэн тохиолдолд тэдгээр хөрөнгийн зах зээлийн бодит үнэ цэнээр хөрөнгө оруулалтын анхны өртгийг тодорхойлж бүртгэнэ.

ӨР ТӨЛБӨР

Компанийн нийт өр нь богино болон урт хугацаатөр төлбөрүүдээс бүрдэнэ юм. Өр төлбөрүүдийг компани, хувь хүмүүст өгөх өглөг, банкны богино хугацаат зээл, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг болон бусад богино хугацаат өглөг,банкны урт хугацаат зээл гэж ангилсан.

Өр төлбөрийг нэрлэсэн үнээр бүртгэж тайлагнана. Тайлант онд компаниас төлөх өр төлбөрүүдэд хөнгөлөлт ба хасагдуулга тооцогдоогүй.

ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

Хувь нийлүүлэгчдээс компанид анх оруулсан хөрөнгө нь энгийн хувьцаа бөгөөд нэмж оруулсан хөрөнгө байхгүй. Тайлангийн өмнөх үеийн ба тайлант оны хуримтлагдсан ашгийг тооцоологдсон дүнгээр хүлээнзөвшөөрч өөрийн хөрөнгийн бүлэгт тусган үзүүлнэ.

НОГДОЛ АШИГ

Тайлант үеийн цэвэр ашгийн хэмжээ болон хувьцааны өмчлөлийн хувийн жинд үндэслэн хувьцаа эзэмшигчдэд ноогдол ашгийг хуваарилна. Тайлант онд ноогдол ашиг зарлаагүй байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО

Хөрөнгийн өсөлт эсхүл өр төлбөрийн бууралттай холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийн нэмэгдэлт үүссэн бөгөөд түүнийг найдвартай хэмжиж чадах тохиолдолд орлогын тайланд орлогыг хүлээн зөвшөөрнө. Орлогыг хүлээн авсан мөнгө эсхүл үүссэн авлагын бодит үнэ цэнээр үнэлнэ.

Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн түвшинг ашиглан тооцож, үнэлнэ. Гэрээний дагуу нэмэлт төлбөр, хойшлогдсон орлого, зардал гараагүй нөхцөлд хүүгийн орлогыг гэрээнд заасан нэрлэсэн хүүгийн хувь хэмжээгээр тооцож, үнэлнэ. Хямдруулалт, урамшуулал, хойшлуулсан орлого, зардлыг холбогдох санхүүгийн хэрэгслийн хугацаанд үр ашигт хүүгийн аргаар хуваарилж, бүртгэнэ.

ЗАРДАЛ

Компанийн үйл ажиллагаатай холбоотой зардлууд болон бусад үйл ажиллагаанд ашиглагдаж буй зардлуудыг аккруэл сууриар хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Зардлуудыг нягтлан бодох бүртгэлийн ба санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох заавар журмын аргачлалд нийцүүлэн төрлөөр ангилж орлогын тайланд үзүүлнэ.

ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР

Монгол улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу компани санхүүгийн жилийн татварногдуулах орлого, түүнд ногдуулсан орлогын албантатварыг тодорхойлж тайлагнана. Энэ хуулиар компанинь 6 тэрбум төгрөг хүртэлх татвар ногдох орлогод 10 хувь, 6 тэрбум төгрөгөөс давсан татвар ногдох орлогод 25 хувийн татвар тооцож төлдөг.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ

Монгол улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн дагууажиллагчдад олгосон цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дүнгээс шимтгэл тооцож нийгмийн даатгалын санд төвлөрүүлэн тайлагнадаг.

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиар ажиллагчдад олгосон цалин, түүнтэй адилтгах орлогоос "Хувь хүний орлогын албан татварын тухай" хуулийн дагуу татвар ногдуулан суутгадаг.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2024.03.11

ҮЗҮҮЛЭЛТ	2022.12.31	2023.12.31
4. МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ		
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах	427,235,488.49	570,297,031.10
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж	-	623,509,900.00
Замд яваа тоологдоогүй мөнгө	14,043,822.95	-
ДҮН	441,279,311.44	1,193,806,931.10

Тайлбар: Компани нь Хаан банкны 5 харилцах, Голомтын 3 харилцах, Төрөвэр хөгжлийн банкны 2 харилцах, 3 хадгаламжтай байна.

ҮЗҮҮЛЭЛТ **5. ЗЭЭЛ**	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	НЭМЭГДСЭН	ХАСАГДСАН		ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
			МӨНГӨӨР/ ЗЭЭЛ	ДАНСНААС ХАССАН/ САНГААС ХАССАН	
Хэвийн зээл-Иргэд /төгрөг/	9,870,517,100.06	158,017,351,400.73	143,188,085,491.92	3,379,791,530.23	21,319,991,478.64
Хугацаа хэтэрсэн зээл - Иргэд /төгрөг/	143,360,561.99	811,638,756.61	479,455,134.02	229,972,492.18	245,571,692.40
Хэвийн бус зээл - Иргэд /Чанаргүй зээл, төгрөг/	190,576,870.63	370,497,185.92	225,188,073.01	211,988,751.08	123,897,232.46
Эргэлзээтэй зээл - Иргэд / төгрөг/	300,046,777.47	230,335,268.54	180,235,645.31	170,538,409.76	179,607,990.94
Муу зээл - Иргэд / төгрөг /	16,518,608.47	451,537,371.10	91,436,067.41	15,799,886.29	360,820,025.87
Муу зээл шүүх	-	276,359.00	-	-	276,359.00
Хасах нь: Зээлийн эрсдэлийн сан	(221,354,242.81)	(436,524,134.80)	-	(163,725,104.54)	(494,153,273.07)
ДҮН	10,299,665,675.81	159,445,112,207.10	144,164,400,411.67	3,844,365,965.00	21,736,011,506.24

Тайлбар: Компани нь Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн 998 дугаар тогтоол "Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-н дагуу зээлээ ангилдаг бөгөөд зээлийн эрсдэлийн санг мөн энэ журмын дагуу байгуулдаг байна. Тус аппликейшн дээр зээлдэгч бүрээр мэдээлэл гардаг, санхүүгийн тайланд зээлийг бүртгэхдээ зээлийн ангиллаар нийлбэр дүнгээр нь бүртгэдэг.

ҮЗҮҮЛЭЛТ	2022.12.31	2023.12.31
6. ХУРИМТЛУУЛЖ ТООЦСОН ХҮҮГИЙН АВЛАГА		
Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага	544,801,473.54	1,189,326,751.85
Хуримтлуулж тооцсон нэмэгдүүлсэн хүүний авлага	54,153,747.81	153,064,819.04
ДҮН	598,955,221.35	1,342,391,570.89

Тайлбар: Компани нь:

Барьцаалан зээлдүүлэх 1 /100.0 мянган төгрөг - 300.0 мянган төгрөг/,

Барьцаалан зээлдүүлэх 2 /200.0 мянган төгрөг - 500.0 мянган төгрөг/,

Барьцаалан зээлдүүлэх 3 /300.0 мянган төгрөг - 600.0 мянган төгрөг/,

Барьцаалан зээлдүүлэх 4 /600.0 мянган төгрөг - 1,520.0 мянган төгрөг/ гэсэн дөрвөн төрлийн зээл гаргадаг бөгөөд барьцаалан зээлдүүлэх 1, 2 нь 8.1 хувийн нэрлэсэн хүүтэйгээр, барьцаалан зээлдүүлэх 3 нь зээлийн дүнгийн дээд хязгаарт хүрвэл 0.9 хувиар нэрлэсэн хүү буурдаг. Барьцаалан зээлдүүлэх 4 нь дээд хязгаартаа хүрвэл нэрлэсэн хүү нь 4.2 хувь болж буурдаг байна. Нэмэгдүүлсэн хүүг хугацаа хэтэрсэн зээлээс Монгол банкны ерөнхийлөгчийн 2018 оны 07 дугаар сарын 23-ны А/203 дугаар тушаал "Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам"-н дагуу тооцоолдог.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2024.03.11

ҮЗҮҮЛЭЛТ	2022.12.31	2023.12.31
7. БУСАД АВЛАГА		
Бусад авлага	17,933,362.00	9,756,724.69
Шүүх тэмдэгтийн хураамжийн авлага	1,039,894.50	2,390,217.56
Шүүх нотариатын авлага	218,140.00	529,586.20
Шүүх шуудангийн авлага	61,400.00	150,464.00
Шатахууны авлага	126,603.00	15,000.00
Бусад ажилчдаас авах авлага	683,187.52	9,619,103.42
ДҮН	20,062,587.02	22,461,095.87

ҮЗҮҮЛЭЛТ	2022.12.31	2023.12.31
8. БУСАД САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ		
Урьдчилж төлсөн тооцоо	1,565,850.00	114,130,897.31
Бараа материал	1,900,070.00	9,318,864.00
ДҮН	3,465,920.00	123,449,761.31

ҮЗҮҮЛЭЛТ	ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	КОМПЬЮТЕР, ДАГАЛДАХ ХЭРЭГСЭЛ	ТАВИЛГА ЭД ХОГШИЛ
9. ҮНДСЭН ХӨРӨНГӨ			
ҮНДСЭН ХӨРӨНГӨ /ӨРТӨГ/			
Эхний үлдэгдэл	55,490,000.00	76,304,050.00	36,030,560.00
Нэмэгдсэн дүн	140,000,000.00	24,189,255.00	11,571,080.00
Хасагдсан дүн			506,850.00
Эцсийн үлдэгдэл	195,490,000.00	100,493,305.00	47,094,790.00
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ			
Эхний үлдэгдэл	2,477,833.35	30,203,375.11	2,692,148.39
Нэмэгдсэн дүн	15,103,302.80	41,805,788.80	4,768,340.57
Хасагдсан дүн			76,330.39
Эцсийн үлдэгдэл	17,581,136.15	72,009,163.91	7,384,158.57
ДҮН	177,908,863.85	28,484,141.09	39,710,631.43

Тайлбар: Тайлант онд Компани нь үйл ажиллагаа явуулж эхэлсэнтэй холбоотойгоор шаардлагатай үндсэн хөрөнгүүдийг худалдаж авсан. Компанийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу худалдаж авсан хөрөнгүүдийг ашиглаж эхлэх боломжтой болсон үеэс элэгдүүлж эхэлсэн.

ҮЗҮҮЛЭЛТ	ЗӨӨЛИЙН АППЛИКЕЙШН	САНХҮҮГИЙН ПРОГРАММ	УТАСНЫ ДУГААР
10. БИЕТ БУС ХӨРӨНГӨ			
Эхний үлдэгдэл	-	7,096,018.51	71,633,333.42
Нэмэгдсэн дүн	4,339,951,894.33	1,404,971.70	20,960,738.71
Хасагдсан дүн	2,260,306,516.24	5,148,579.20	75,079,708.25
ДҮН	2,079,645,378.09	3,352,411.01	17,514,363.88

Тайлбар: Тайлант онд байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашигладаг "Тус" аппликейшнийг дахин үнэлүүлсэн. Үүнтэй холбоотойгоор дахин үнэлгээний нэмэгдлийн дүнгээр аппликейшний 2023 оны 10 дугаар сарын 08-нд дансны үнийг 2,222,645.0 мянган төгрөгөөр нэм.

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2024.03.11

ҮЗҮҮЛЭЛТ	2022.12.31	2023.12.31
11. БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС ТАТСАН ЭХ ҮҮСВЭР		
Төлөгдөх хугацаандаа байгаа зээл	1,087,688,500.00	2,353,623,661.11
Хугацаа хэтэрсэн зээл	-	-
Банк, санхүүгийн байгууллага, иргэнээс татсан эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	283,761,987.39	545,068,596.11
ДҮН	1,371,450,487.39	2,898,692,257.22

Тайлбар: Компани нь 2023 оны 12 дугаар сарын 28-нд Тээвэр хөгжлийн банкнаас хадгаламж барьцаалсан 28 хоногийн хугацаатай сарын 1.38 хувийн хүүтэй 320,000.0 мянган төгрөгийн зээл, "Бэрс Финанс ББСБ" ХХК-иас 2,950,000.0 мянган төгрөгийн зээл тус тус авсан байна. Хүүгийн өглөгт тайлант хугацаанд гаргасан өрийн хэрэгслийн/бондын/ хүүний өглөг болон банк санхүүгийн байгууллагаас авсан богино, урт хугацаат зээлийн хүүгийн өглөг багтаж байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2022.12.31	2023.12.31
12. БУСАД САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР		
Цалингийн өглөг	29,094,264.06	65,240,746.39
Бусад богино хугацаат өр төлбөр	47,856,125.32	5,018,451,228.95
Урт хугацаат зээл	4,321,508,000.00	4,295,508,000.00
ДҮН	4,398,458,389.38	9,379,199,975.34

Тайлбар: Бусад богино хугацаат өр төлбөр өмнөх оноос 103.9 хувиар өссөн нь тайлант онд 6 сараас 12 сарын хугацаатайгаар жилд нэг болон хоёр удаа хүү төлөх нөхцөлтэйгөөр 18 хувиас 21.6 хувийн хүүтэйгээр зээл авснаас шалтгаалжээ. Зээл авахдаа зээлдэгч тал болох "Тус Финтек ББСБ" ХХК, андеррайтерын тал болох "Өлзий Энд Ко Капитал УЦК" ХХК болон зээлдүүлэгч тал хувь хүн болон байгууллагын гуравласан гэрээгээр баталгаажсан байна. Зээл нь "Тус Финтек ББСБ" ХХК, түүний хувьцаа эзэмшигч болон андеррайтерын хооронд 2023 оны 09 дүгээр сарын 11-ны өдөр байгуулагдсан БД-23/06 тоот Батлан даалтын гэрээгээр баталгаажсан. Компани нь холбоотой тал болох "Тус Финтек Инвестмент" ХХК-иас 2022 оны 09 дүгээр сарын 20-нд 10,000,000.0 мянган төгрөгийн сарын 1.4-2.3 хувийн хүүтэйгээр, 60 сарын хугацаатайгаар шугаман зээлийн гэрээ байгуулсан байна. Үүний дагуу тайлант хугацаанд тухайн компаниас 1,685,500.0 мянган төгрөгийг зээл авсан байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2022.12.31	2023.12.31
13. ТАТВАР, НДШ-ИЙН ӨР ТӨЛБӨР		
ААНОАТ-н өглөг	328,653,502.20	744,593,425.08
Хуулийн этгээдээс суутгасан ХХОАТ өглөг	-	1,600,000.00
Хувь хүнээс суутгасан ХХОАТ өглөг	-	150,000.00
ЭМД, НДШ-н өглөг	20,632,146.88	11,269,889.02
Цалингаас суутгасан ХХОАТ өглөг	28,657,262.69	74,811,294.22
Бусад татварын өглөг	-	27,337,081.63
ДҮН	377,942,911.77	859,761,689.95

ҮЗҮҮЛЭЛТ	2022.12.31	2023.12.31
14. ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ТҮҮНИЙ УДИРДЛАГА		
Энгийн хувьцаа	2,500,000,000.00	2,500,000,000.00
ДҮН	2,500,000,000.00	2,500,000,000.00

ҮЗҮҮЛЭЛТ	2022.12.31	2023.12.31
15. ХӨРӨНГИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ		
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	2,211,751,431.00
ДҮН	-	2,211,751,431.00

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2024.03.11

ҮЗҮҮЛЭЛТ **16. ХУРИМТЛАГДСАН АШИГ/АЛДАГДАЛ**	2022.12.31	2023.12.31
Хуримтлагдсан ашиг/(алдагдал)	2,926,757,532.24	8,928,161,181.25
ДҮН	2,926,757,532.24	8,928,161,181.25

ҮЗҮҮЛЭЛТ **17. ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ОРЛОГО/ЗАРДАЛ**	2022.12.31	2023.12.31
Хүүгийн орлого	**5,618,702,501.70**	**11,518,182,657.80**
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	5,502,333,759.66	11,238,387,689.62
Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	116,368,742.04	265,640,465.61
Харилцах дансны хүүгийн орлого	-	184,201.54
Банкин дахь хадгаламжийн хүүгийн орлого	-	13,970,301.03
Хүүгийн зардал	**803,383,166.55**	**1,771,938,838.87**
Банкны байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал	803,383,166.55	-
Бусад санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал	-	1,771,938,838.87
ДҮН	4,815,319,335.15	9,746,243,818.93

ҮЗҮҮЛЭЛТ **18. ЦЭВЭР ХӨРӨНГИЙН БУС ОРЛОГО/ЗАРДАЛ**	2022.12.31	2023.12.31
Хүүгийн бус орлого	**104,082,851.60**	**470,458,922.03**
Санхүүгийн үйлчилгээний шимтгэл	104,082,851.60	470,458,922.03
Хүүгийн бус зардал	**1,364,641,416.10**	**2,997,215,638.26**
Боловсон хүчний холбогдолтой зардал	775,650,089.10	1,690,833,867.22
Бусад зардал	588,991,327.00	1,306,381,771.04
ДҮН	(1,260,558,564.50)	(2,526,756,716.23)

Тайлбар: Тайлант онд 98 ажилтанд 1,459,832.7 мянган төгрөгийн цалин, урамшуулал олгосон байна. Үүнд 840,272.3 мянган төгрөгийн бодогдсон цалин, 582,294.7 мянган төгрөгийн нэмэгдэл болон урамшуулал, 53,907.4 мянган төгрөгийн хоолны нэмэгдэл, 74,544.8 мянган төгрөгийн амралтын мөнгө тус тус эзэлж байна. Тайлант онд ажилчдын цалин урамшууллаас хуулийн дагуу суутгалуудыг суутгасан бөгөөд нийгмийн даатгалын шимтгэлд компаниас 181,922.9 мянган төгрөгийг суутгасан байна.

ҮЗҮҮЛЭЛТ **19.ЭРСДЭЛИЙН САНГИЙН ЗАРДАЛ**	2022.12.31	2023.12.31
Зээлийн эрсдэлийн сангийн зардал	221,354,242.81	273,789,292.20
ДҮН	221,354,242.81	273,789,292.20

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2024. 03. 11

ҮЗҮҮЛЭЛТ **20.ЕРДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ/АЛДАГДАЛ**	2022.12.31	2023.12.31
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	**-**	**6,949,142.82**
Бусад орлого	-	6,949,142.82
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	**65,350,903.01**	**164,920,621.11**
Зочин төлөөлөгчийн зардал	33,198,202.00	-
Торгуулийн зардал	-	190,000.00
Хөрөнгө данснаас хассаны гарз	485,936.56	-
Баяр ёслол	-	131,700,292.00
Бусад зардал	31,666,764.45	33,030,329.11
ДҮН	(65,350,903.01)	(157,971,478.29)

ҮЗҮҮЛЭЛТ **21.ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ**	2022.12.31	2023.12.31
Орлогын татварын зардал	328,653,502.02	797,216,283.12
ДҮН	328,653,502.02	797,216,283.12

ҮЗҮҮЛЭЛТ **22.ТЭРГҮҮЛЭХ УДИРДЛАГЫН БҮРЭЛДЭХҮҮНД ОЛГОСОН НӨХӨН ОЛГОВРЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ ТЭРГҮҮЛЭХ УДИРДЛАГА ГЭДЭГТ**	2022.12.31	2023.12.31
Цалин, богино болон урт хугацааны тэтгэмж	69,854,708.02	190,345,454.54
Нийгмийн даатгалын шимтгэл	8,731,838.52	23,793,181.83
Ажил эрхлэлтийн дараах, ажлаас халагдсаны тэтгэмж		
Хувьцаанд суурилсан төлбөр		
ДҮН	78,586,546.54	214,138,636.37

Тайлбар: Тэргүүлэх удирдлага гэдэгт гүйцэтгэх захирлыг авч үзсэн бөгөөд тэргүүлэх удирдлагын цалин өмнөх оноос 172.5 хувиар өссөн нь тэргүүлэх удирдлагад 2023 оны 03 дугаар сарын 23-ны 23/23А/11 дүгээр тушаалаар 100,000.0 мянган төгрөгийн урамшуулал олгогдсон нь нөлөөлжээ.

ҮЗҮҮЛЭЛТ **23. ХОЛБООТОЙ ТАЛУУДАД ӨГӨХ ӨГЛӨГ**	2022.12.31	2023.12.31
"Тус Финтек Инвестмент" ХХК	5,692,958,487.39	4,586,333,399.74
ДҮН	5,692,958,487.39	4,586,333,399.74

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2024.03.11

24. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА БА БОЛЗОШГҮЙ ЗҮЙЛС

Компани нь Тус зээлийн аппликейшнээр дамжуулан бүртгүүлсэн хэрэглэгчдэд ямар нэгэн барьцаагүйгээр зээл олгодог. Үүнтэй холбоотойгоор тайлант үед тодорхой тооны хэрэглэгчдийн зээлийн эргэн төлөлттэй холбоотой асуудал үүссэн боловч Компанийн үйл ажиллагаанд мэдэгдэхүйц эрсдэл үүсгэхүйц биш байна.

25. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

Энэхүү тайланг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдөр бэлтгэсэн. Тасалбар болгосноос хойш тайлант нөлөөлөх /залруулагдах/ үйл явдал гараагүй.

26. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Компанид Тодруулгын "Үүрэг хариуцлага ба болзошгүй зүйлс" хэсэгт тусгагдсан эрсдэлүүдээс гадна санхүүгийн хэрэгслүүдийг хэрэглэх явцад дараах нийтлэг эрсдэлүүд тулгарч болно.

- Хэрэглэгчийн санаатай болон санамсаргүй байдлын улмаас өөрт нь үүссэн хохирлыг Компани хариуцахгүй бөгөөд зээлийн аппликейшний нууц үг, нэвтрэх нэр зэрэг нь хэрэглэгчийн өмч юм.
- Компанийн үйл ажиллагаа нь интернэт орчинд явагддаг тул сервер гэмтсэнээс үүдэн аппликейшний үйл ажиллагаа хэдэн өдөр саатсан явдал тохиолдож байсан тул цаашид ийм эрсдэл гарч болно.

ИНТЕР АУДИТ ХХК
№01 ОНОО 2024.03.11

“ИНТЕР АУДИТ” ХХК

Аудитын компанийн хаяг:
Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, 6-р хороолол, Самбуугийн гудамж, Эм Эн тауэр 802 тоот

Холбогдох:

Утас: 99004839

Веб хуудас: www.interaudit.mn
Фэйсбүүк хуудас: Интер Аудит ХХК / Inter Audit LLC
Мэйл хаяг: info@interaudit.mn